



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №07


2019 оны 3-р сарын 04-07

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ


Улсын хэмжээнд 2019 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт 49 яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 39(79.6) галзуугийн эрсдэлд өртсөн, 5(10.2%) хачигт халдвар, 2(4.1%) хумхаа, 1(2%) ям, 1(2%) денги, 1(2%) бэтэг өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

1.1. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Он гарсаар Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хэнтий, Завхан аймгийн 15 сум, нийслэлийн 3 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 39 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 63%-иар их байна. Эпидемиологийн 9-р долоо хоногтой харьцуулахад 2 тохиолдлоор бага үзүүлэлттэй байна.



Галзуу өвчний сэжигтэй зэрлэг, мал амьтанд уруулж, ноцуулан, шүлсдүүлсэн хүмүүсийн тохиолдлыг эх уурхайгаар нь авч үзвэл: чононд (30.8%) эзэнтэй нохойд (20.5%), үнэгэнд (17.9%), эзэнгүй нохойд (17.9%), мануулд (7.7%), тэмээнд (2.6%) нь уруулсан байна.



Энэ долоо хоногт Ховд аймгийн Жаргалант сумаас галзуу өвчний эрсдэлд өртсөн 1 тохиолдол бүртгэгдсэн байна. Эрсдэлд өртсөн тохиолдол эмнэлэгт хандаж 3-р сарын 01-нд галзуугийн эсрэг вакцины эхний тунд хамрагдсан байна.

Хариу арга хэмжээний, зөвлөмж:

- **Ховд аймгийн ЗӨСТ** галзуу өвчнөөс сэргийлэх, сэрэмжлүүлэг сурталчилгааг эрчимжүүлэн ажиллах.

Монгол улсад:

Галзуу өвчний мал, амьтны өвчлөл:

Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын Аргалант багийн “Завуудын халцгай” гэдэг газар малчин “Б”-ийн 1 ямаа 3-р сарын 01-ний өдөр галзуу өвчний шинж тэмдэгтэй хорогдсон тул дээж авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд галзуу өвчин болох нь тогтоогдсон. Тус сумын Засаг даргын захирамжаар 3-р сарын 01-ний өдөр 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосон байна.


Эх сурвалж: ОБЕГ

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Олон улсад:

Эбола вирус халдвар:

2019 оны 2-р сарын 28-ны өдрийн ДЭМБ-ын мэдээлснээр Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вирус халдварын сэжигтэй 879 тохиолдол (814 батлагдсан, 65 болзошгүй) бүртгэгдэж, үүнээс 553(63%) тохиолдол нас барсан байна. Нийт тохиолдлын 499(57%) нь эмэгтэйчүүд, 264(30%) нь 18-аас доош насны хүүхдүүд тус тус эзэлж байна. Тус улсад тандалт судалгаа үргэлжилж байна.




Зураг 1. Эбола вирус халдвар, Бүгд Найрамдах Ардчилсан Конго улс

Эх сурвалж: ДЭМБ

Гахайн сонгомол мялзан өвчин:

2019 оны 3-р сарын 01-ний өдөр Япон улсын Хөдөө аж ахуйн яамнаас мэдээлснээр 2-р сарын 25-нд Гифу мужид Гахайн сонгомол мялзан өвчний халдвар бүртгэгдсэн. Тус гахайн фермд өвчилсөн 1 гахайг устгасан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:


2019 оны 3-р сарын 01-нд БНХАУ-ын Хөдөө аж ахуйн яамнаас мэдээлснээр Шааньси мужид Африкийн гахайн мялзан өвчнөөр 11334 гахай өртөмхий байснаас, 150 нь өвчилж, 62 гахай өвчилж үхэн, 3470 гахайг устгасан байна.



Эх сурвалж: ДАЭМБ


Ласса чичрээгийн халдвар:

Нигер улсад Ласса чичрээгийн халдвар 2019 оны 01-р сарын 01-нээс, 2-р сарын 24-ний хүртлэх хугацаанд 1249 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс 381 нь батлагдаж, 83 нь нас барсан тухай нийтэлсэн байна. Нас баралтын түвшин 21.8% байна.



Зураг 1. Ласса чичрээгийн халдварын эпидемиологийн 7 хоногоор

Дээрхи тохиолдлууд Нигер улсын 66 мужын 21 хотод (Эдо, Ондо, Ваучи, Тарава, Гомбэ, Квара, Венуй, Коги, Имо) бүртгэгджээ.



Эх сурвалж: Promed, Нигерийн ӨХСТ

MERS-CoV-ийн халдвар:

Саудын Араб улсын Мал амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 3-р сарын 04-ний өдөр MERS-CoV-ийн халдвар Ар Рияд хотод бүртгэгдсэн байна. Нийт 17 тэмээнээс 8 тэмээ өвчилсөн тухай ДАЭМБ-аас нийтэлсэн байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

Румын улсын Хөдөө аж ахуйн яамны 2019 оны 3-р сарын 06-ны мэдээгээр Бузэу хотын нэгэн бүс нутгийн ойд Африкийн гахайн мялзан өвчин бүртгэгдэж, 1 зэрлэг гахай өвчилж үхсэн тухай ДАЭМБ-аас нийтэлжээ.



Эх сурвалж: ДАЭМБ

MERS-CoV-ийн халдвар:

Саудын Араб улсын ЭМЯ-ны мэдээлнээр MERS-CoV-ийн халдварын нийт 91 тохиолдол бүртгэгдсэнээс 52 тохиолдол нь Вади эд-Давасир-аас мэдээлэгдсэн байна.



Тус улсад хамгийн сүүлийн MERS-CoV-ийн халдварын 1 тохиолдол 2019 оны 3-р сарын 06-нд бүртгэгдсэн байна. Халдвар авсан 45 настай эмэгтэй, Ридих мужид амьдардаг, тэмээтэй хавьтал болоогүй тухай нийтэлсэн байна.

Эх сурвалж: Promed